

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

I. ТӨСӨВ: 2013 оны 1-р сарын 1-нээс “Төсвийн тухай хууль” шинээр хэрэгжиж эхэлснээр сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, соёлын байгууллагууд, хүүхэд гэр бүлийн хэлтэс, газрын алба, халамж асрамжийн үйлчилгээ зэрэг зардлууд орон нутгийн төсвөөс санхүүжих болсонтой холбоотойгоор төсвийн зардал ихээр нэмэгдэж байна.

Мөн орлогын хувьд орон нутагт төвлөрдөг байсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, лицензийн төлбөр нь улсын төсөвт төвлөрдөг болсон. Дээр нэмэгдэж буй зардлыг санхүүжүүлэх зорилгоор улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг орон нутгийн төсөвт оруулдаг болсон. Аймгийн төсвийн орлогод 45.5 тэрбум төгрөг орж, төлөвлөгөөгөө 99.2 хувиар биелээд байна.

Аймгийн төсвийн нийт зарлага 37.9 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 38.1 тэрбум төгрөг болж төлөвлөгдсөн зардлын 100.6 хувийг буюу гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн. Сумдын төсвийн зарлага 24.7 тэрбум төгрөг болж төлөвлөгдсөн зардлын 97.8 хувийг зарцуулсан байна.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хас, Голомт, Төрийн банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 73.6 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 26.6 тэрбум төгрөгөөр өссөн байна. Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл 25.5 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 186.2 сая төгрөгөөр өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Газар тариалан: Үр тариа 430 тн, төмс 709.8 тн, хүнсний ногоо 272.7 тн, тэжээлийн ургамал 40.5 тн, техникийн ургамал 20 тн-ыг тус тус хураагаад байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төмс 26.6 тн, хүнсний ногоо 49.6 тн-оор тус тус дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Байгалийн хадлан 11.9 мянган тн, гар тэжээл 657.5 тн тус тус бэлтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс хадлан 183.5 тн-оор дээгүүр, гар тэжээл 73.5 тн-оор доогуур гүйцэтгэлтэй байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 26.3 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 2.7 тэрбум төгрөгөөр буюу 9.5 хувиар доогуур байна. Оны үнээр 101.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 22.0 тэрбум төгрөгөөр доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс бялуу, аарц, тоосго, угаалтуур, түмпэн, тогооны таг, хогийн утгуур, савар, агааржуулагч, галын хайч, хаалт, жигнүүр, усны тэрэг, ууж, хүрэм, баривч, монгол цамц, том дээл, гутал, блок, замын хавтан, бордиур, хайрга, яндан, пийшин, түлээний авдар, сандал, эсгийний үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.

V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 11-р сард өмнөх сарынхаас 1.2 хувь, оны эхнээс 9.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 10 хувиар өслөө. Ерөнхий индекс оны эхнээс өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 10.6 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ 15.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 10.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 15.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 23.6 хувь, боловсролын бүлгийн үнэ 30.0 хувь, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 18.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

VI. ЭРҮҮЛ МЭНД: Эхний 11-н сард 1124 эх амаржиж, 1130 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс доогуур байна. Халдварт өвчнөөр 949 хүн өвчилсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 383-аар олон байгаа бөгөөд гахай хавдар, тэмбүү, салхинцэцэг, сүрьеэ, заг, трихоминиаз зэрэг өвчлөлүүд өссөн байна.

VII. АЖИЛГҮЙЧҮҮД: Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 249 болж, өнгөрсөн оны мөн үеэс 69.2 хувиар буурсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 69.8 хувь нь 15-34 насны залуучууд байна. Боловсролын түвшинээр авч үзвэл 28.1 хувь нь дээд, 5.6 хувь нь тусгай дунд, 37.8 хувь нь бүрэн дунд, 10.8 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний 11-р сарын байдлаар 2619 хүн шинээр бүртгүүлж, 1647 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 808 хүн ажиллаж байна.

VIII. ГЭМТ ХЭРЭГ: 295 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 64-өөр дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 31 хүн нас барж, 120 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 557.9 сая төгрөгийн хохирол учирсны 77.0 хувийг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 300 хүн холбогдон сэжиглэгдсэний 34.6 хувь нь согтуугаар, 25 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна. Нийт 2614 хүн эрүүлжигдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 312 хүнээр буурсан байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 266 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.



АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС